

Байгалийн ухааны багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн / Физик /, Цэндээ Цэрэндорж

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагын болон хүний нөөцийн чадавх, хөгжлийг хангах, бүх шатны сургалтын байгууллагын хөгжил, удирдлагатай холбоотой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх							
1	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.	хэрэгжилтийн хувь	90	50	Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22 ны А/25 тоот тушаалаар баталсан Багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны журамд заасан "Багшийг дадлагажуулах" үйл ажиллагааны жишиг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг ахлан ажиллаа.Жишиг хөтөлбөрийг боловсруулахдаа БАБХГ-ын мэргэжилтнүүд, Багшийн хөгжлийн дэмжих үндэсний төвийн санал, шүүмжийг тусгахын зэрэгцээ ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийн саналыг тусгалаа.Мөн Кембрижийн ментор үйл ажиллагааны хөтөлбөрийг судаллаа.Ажлын хэсэг жишиг хөтөлбөрийг 2 удаа хэлэлцүүлж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Боловсролын ерөнхий газрын даргаар батлуулан сургалтын байгууллагуудад албан бичгээр хүргүүлээ. Хавсралт: 1 файл		
2	Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үндсэн сургалт зохион байгуулах.	оролцогчдын тоо, хувь	137, 81	156, 90	Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулгыг БАБХГ-ын арга зүйч нартаа хамтран боловсрууллаа.Түүний дотор "Эргэцүүлэд суурилсан багшийн хөгжил" сэдэвт 4 цагийн агуулыг математикийн мэргэжилтэн Д.Отгонтуяатай хамтран боловсруулсан. Энэ удаагийн үндсэн сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд Ховд, Баян-Өлгий, Төв аймаг, нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Хан-Уул дүүргийн багш нарт 2 өдрийн танхимын сургалт зохион байгуулсан. Багшийн хөгжлийг дэмжих bagsh.edu.mn платформд суурилан 28 өдрийн цахим сургалтыг физикийн багш нарт зохион байгуулсан. Тус сургалтад 126 багш хамрагдаж 100/80% багш амжилттай суралцаж батламжаа авсан.Физикийн багш нарын цахим сургалтаар танхимын сургалтын агуулгыг бататган, гүнзгийрүүлж, физикийн хичээлийн ээлжит хичээл боловсруулах "6D арга зүй"-г судалж, багш бүр ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулан, ажлын байрандаа хичээл зохион байгуулсан.Сургалтын үр дүнг ажлын байрандаа хэрэгжүүлж буй	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					сайн туршлагыг илрүүлэн Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар түгээн дэлгэрүүллээ: Хавсралт: 3 файл		
3	Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэх.	цахим сургалтын тоо	0	12	Сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан өөрсдийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломж бий болгох зорилт тавин ажиллаж байна.Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформ суурилан суралцах боломжтой болж байна.Боловсролын ерөнхий газраас 2023-2024 онд зохион байгуулсан модуль сургалтын үр дүнгийн судалгаа, мониторингоос багш нараас хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг сонгож, боловсруулсан багтай гэрээ байгуулан БЕГ-ын өмчид авсан.Манай байгууллага гэрээний дагуу тус 12 модулийг ашиглан сургалт зохион байгуулах эрхтэй. Багшийн хөгжлийн Bagsh.edu.mn платформд 12 модулийг байршуулсан бөгөөд багш нар сонголтоороо үнэ төлбөргүй судалж, амжилттай төгсвөл батламж авах боломжийг бүрдүүллээ. Хавсралт: 1 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
4	Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх.	оролцогчдын тоо, хэрэгжилтийн хувь	20, 100	-	Бэлтгэл ажил хангаж байна.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

						сар	
5	Сургуулийн өмнөх боловсрол ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн “Зөвлөх”, “Тэргүүлэх” зэрэг олгох дүгнэлт гаргах.	хэрэгжилтийн хувь	100	50	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд "зөвлөх" , " тэргүүлэх" мэргэшлийн зэрэг олгох ажлын хүрээнд физикийн 1, биеийн тамирын 2, мэдээлэл технологийн 3 нийт 6 багшийн мэргэшлийн зэрэг авах хүсэлтийг хүлээн авч, шалгуурын дагуу ирүүлсэн материалд хяналт, үнэлгээ хийж дүгнэлт гаргасан.Нийт 4 багшийн ирүүлсэн материал шалгуур хангаж, тэргүүлэх, зөвлөх зэрэг авах боломжтой гэж дүгнэн хариуцсан мэргэжилтэнд хүргүүллээ Хавсралт: 2 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	50%
6	Сургалтын байгууллагын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, үндэсний хэмжээнд тайлант өдөрлөг зохион байгуулж, үр дүнтэй МХБ-ийн сан бүрдүүлэх.	Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, үр дүнтэй МХБ-ийн тоо	60, 45	116 (МХБ-ийн тоо), 25 (сайн туршлагын тоо)	1.Монгол Улсын Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1 дүгээр хэсэгт мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлэн, шинэчлэх тухай заасан байна.Тус ажлын хүрээнд 2022 онд Боловсролын ерөнхий газраас боловсруулж, хэрэгжүүлсэн "Мэргэжлийн хөгжлийн бүлгийн аргачлал"-ыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.Мэргэжлийн бусад байгууллагуудын саналыг тусган 2025 оны 06 дугаар сардаа багтаан	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	90%

					батлуулж, сургалтын байгуулалгуудад хүргүүлэхээр ажиллаж байна. 2. Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын арга зүйчэд нийслэл, орон нутагт 2 удаа томилолтоор ажиллах явцад 4 сургалтын байгууллагад биечлэн очиж мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн байна. Үүний үр дүнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 19 багшид мэргэжил, арга зүйн зөвлөж зөвлөгөө өгсөн байна. 3. Боловсролын яам бодлогын түвшинд хэрэгжүүлж буй Bagsh.edu.mn платформ дээрх "мэргэжлийн багш нарын бүлгийн модуль" Starsoft ХХК-тай байгуулсан гэрээт ажлын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх ажлын хариуцан зохион байгуулж байна. Тус ажлын хүрээнд Starsoft ХХК, ADB-н төслийн багын хамтрасан уулзалт хэлэлцүүлэгт 4 удаа оролцсон байна.		
7	Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд гадаад улсын Боловсролын газартай туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах.	Туршлага солилцсон албан хаагчийн тоо	Нийт 6 албан хаагч хамрагдсан.	-	Бэлтгэл ажил хангаж байна. 2025 оны 2 дугаар хагаст зохион байгуулахаар төлөвлөсөн.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
8	СӨБ болон ЕБС-ийн багш, ажилтны	хэрэгжилтийн хувь	100	50	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 1, 2 дугаар ангийн	2-р сар, 3-р сар, 4-р сар,	100%

	мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах.				сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, хөтөлбөрийг багш нарт сургалт, үйл ажиллагаагаар хүргэх үндэсний төлөвлөгөөний төсөл гаргах зорилгоор Ховд аймагт 2 хоног ажиллалаа.Ховд аймгийн Боловсролын газрын хэлтсийн дарга, мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, багш нарын төлөөлөл 25 албан хаагч нартаа хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулж төлөвлөлтийн зураглал гаргасан.Боловсролын ерөнхий газрын ажлын хэсэгт төлөвлөлтийн зураглалаа танилцуулж, хэлэлцүүлэн үндэсний төлөвлөлтийн төслийг хамтран боловруулсан байна. Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	
--	--	--	--	--	---	---	--

3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах

9	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Биелэлт /хувь/	100%	50	1. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн сургалт арга зүйн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх сургалтын зохион байгуулалтыг хийж, агуулга боловсруулах баг, сургалтын багт ажиллаа.2.Азийн хөгжлийн банкны "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах" төслийн төлөвлөгөөт ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн захирлуудын мэргэжил, арга зүйг дэмжих, хөгжүүлэх 30 өдрийн цахим платформд суурилсан сургалтыг зохион байгууллаа.Сургалтад 593	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	---	----------------	------	----	---	---	------

					захирал хамрагдаж, 410 захирал амжилттай суралцаж батламжаа гардан авлаа.Сургалтын үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн захирлууд багшийн хөгжилд бодиттой хувь нэмэр оруулж, сургалтын технологи, арга зүй хөгжүүлэлтийн чухал субъект болох хүлээлттэй байна. Сургалтын үр дүнд тодорхой хугацааны дараа төлөвлөгөөний дагуу мониторинг, зөвлөн туслах хийхээр төлөвлөж байна. Хавсралт: 4 файл		
10	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах	Биелэлт /хувь/	100	50	2024-2025 оны хичээлийн жилийн физикийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын зохион байгуулсан талаар удирдамж, тайлан мэдээг нэгтгэн архивт хүлээлгэн өгсөн байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
11	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Биелэлт /хувь/	100	50	2025 оны эхний хагас жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаа.Авилга, ашиг сонирхол, ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдож, 4 удаагийн хуралд оролцож, 11:11	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ирсэн 2 гомдлыг шийдвэрлэсэн байна.		
--	--	--	--	--	-------------------------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах	хэрэгжилтийн хувь	90	50	Захиргаа удирдлагын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан " нийгмийн даатгалын ерөнхий хууль, шинэчлэл" сэдэвт сургалтад хамрагдлаа.Удирдлагын академиэс зохион байгуулсан хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдсан байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
2	Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах	хэрэгжилтийн хувь	100	50	Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн тушаалаар батлагдсан багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам, багш удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны журмыг судалсан. Тус журмын хүрээнд БАБХГ-ын ажиллах хүрээг, чиг үүргийг судалж нэгжийн хамт олонд сургалт зохион байгуулсан.Сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох журмыг уншиж судлан, ажил үүрэгтэй ашиглан хэрэгжүүлж байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Хавсралт: 1 файл		
3	Монгол бичгийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх	хэрэгжилтийн хувь	30	50	Монгол бичгийн дүрмийн номыг бие даан уншиж судалсан. Хавсралт: 2 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Байгалийн ухааны багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн / Физик /, Цэндээ Цэрэндорж
/...../ Огноо: